



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/120

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зэрэг суманд нийлүүлэх “Нөөцийн дизель мотор” ажлыг гүйцэтгэгч “Гэсэмбэ” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ц.Ганданповрон - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Т.Дэлгэрсайхан -Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/

М.Баярт - Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Д.Ням-Очир -“Тээлийн элч” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Нарийн бичгийн

дарга: Ц.Жаргалсайхан - Хөрөнгө оруулалт,хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

2. Зэрэг суманд нийлүүлэх “Нөөцийн дизель мотор” ажлыг гүйцэтгэгч “Гэсэмбэ” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 00536